



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/368

Мандалговь

Шүлхий, бог малын мялзан өвчнөөс  
урьдчилан сэргийлэх вакцинжуулалт  
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Шүлхий өвчний голомт бүхий Сайхан-Овоо сумын хил залгаа Эрдэндалай, Дэлгэрхангай сумдын эрсдэл бүхий нутаг дэвсгэрт тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг мэдрэмтгий мал, амьтныг хамруулан 2018 оны 9 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Хоёр. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг Баянжаргалан, Өндөршил сумын бүх бог малыг хамруулан 2018 оны 9 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд зохион байгуулахыг тухайн сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн арга зүй, удирдлага зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллахыг Хүнс хөдөө аж ахуйн газар (Б.Мөнхжаргал)-т, Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010192

Аймгийн Засаг даргын 2018 оны 9  
дүгээр сарын 7-ны өдрийн тоот  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулах  
малын тоо, вакцины хуваарь

Сумын нэр	Хамруулах мал				Олгох вакцин		Тайлбар
	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Вакцин мл	Вакцин тун	
Сайхан-Овоо	4400	116400	136000	256800	261200	130600	504.8 мянган вакцин ирсэн, аймагт байсан 9.0 мянган тун вакцин нэмж хуваарилагдсан.
Эрдэнэдалай	21000	239000	257000	517000	538000	269000	
Дэлгэрхангай	2800	88866	135355	227021	229821	114200	
Бүгд	28200	444266	528355	1000821	1029021	513800	